



# 2025 ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРУУЛАХ



ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД)  
АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ,  
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА





2025

# ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРУУЛАХ



ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД)  
АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ,  
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



## ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД) АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА 'ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРУУЛАХ'



'ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД) АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ, ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРУУЛАХ' гарын авлагыг цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд) БНСУ-ын цэцэрлэг-бага-дунд-ахлах сургуульд оруулахаар бэлдэж байгаа эцэг эхчүүд ашиглах боломжтой. Энэхүү гарын авлагад хүүхдээ сургуульд оруулахад бэлдэхээс эхлээд хүүхдийг сургуульд нь дасгах үүднээс зохион байгуулдаг төрөл бүрийн мэдээлэл багтсан.

Солонгос сургуульд сурахад хэрэгтэй мэдээлэлд тулгуурлан цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд явахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор бэлтгэн гаргав. Гарын авлагын товч агуулга дараахи бүлгээс бүрдэнэ.

- I. **“Сургуульд ороход бэлдэх”** хэсэгт сургуульд элсэж ороход бэлдэх зүйлс, гадаад хүүхдийн бүрдүүлэх бичиг баримтыг танилцуулна.
- II. **“Сургуулийн элсэлтийн журам”** хэсэгт цэцэрлэг, бага, дунд, ахлах сургуульд элсэж орох хүүхэд, элсэлт авах хугацаа, элсэлтийн журмын тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.
- III. **“Боловсролыг дэмжих тогтолцоо”** хэсэгт сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг, сургууль болон солонгос ахуйд дасахад үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл өгнө.

Энэхүү материал нь цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд) солонгос сургуульд оруулах гэж байгаа эцэг, эхчүүдэд маш ойлгомжтой, амархан ашиглах боломжтой гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.

※ Энэхүү гарын авлагад олон улсын гэр бүлийн хүүхэд, гадаад иргэдийн хүүхдийг цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд) гэж тодорхойлсон бөгөөд насыг нь жинхэнэ насаар нь тооцно.



# СОЛОНГОС УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО



## Боловсролын тогтолцоо, сурагчийн бүртгэл

- ※ Солонгос улсын иргэний харъяалалтай хүүхдийг албан сургалтанд хамруулаагүй тохиолдолд торгууль ногдуулна.
- ※ Үнэ төлбөргүй олгох боловсролд үзүүлэх дэмжлэг: Элсэлтийн хураамж, сургалтын төлбөр, сургуулийн үйл ажиллагааг дэмжих зардал, сурах бичгийн үнэ
- ※ Жич: Хувийн хэвшлийн бага болон дунд(урлаг, биеийн тамир, олон улсын зэрэг) сургууль, гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль, хувийн хэвшлийн ахлах сургууль төлбөртэй.

Сурах хугацаа	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
Солонгосын боловсролын тогтолцоонд шилжүүлбэл	Бага сургуулийн сургалтын хөтөлбөр					Дунд сургуулийн сургалтын хөтөлбөр			Ахлах сургуулийн сургалтын хөтөлбөр			Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр				
Гадаад улсын боловсролын тогтолцоо	5-3-4-4 тогтолцоо		5 жил			3 жил			3 жил			4 жил				
	6-4-3-3 тогтолцоо		6 жил			4 жил			3 жил			3 жил				
	6-3-2-5 тогтолцоо		6 жил			3 жил			2 жил		5 жил					
	2-4-3-4-3 тогтолцоо		2 жил	4 жил		3 жил			4 жил			3 жил				
	8-4-4 тогтолцоо		8 жил						4 жил			4 жил				



## Хичээлийн 1 жилийн үндсэн хөтөлбөр

- \*Хичээлийн жил: 3 сарын 1-нээс дараа жилийн 2 сарын эцэс хүртэлх хугацааг хэлнэ.  
Жишээ) 2025 оны хичээлийн жил (2025.3.1.–2026.2.28.)
- \*Хичээлийн улирал: Солонгосчууд хичээлийн нэг жилийг ихэвчлэн хоёр улиралд хуваадаг.  
Жишээ) 1-р улирал (2025.3.–Зуны амралт), 2-р улирал (1-р улирын сүүлийн өдрийн дараа өдөр–2026.2.)
- \*Хичээлийн амралт: Тухайн сургуулийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан зун, өвлийн амралт эсвэл зун, өвөл, хаврын амралт(хичээлийн жилийн эцсийн амралт) гэж ангилна.

Хөтөлбөрийн нэр	Агуулга	Хугацаа
Хичээлийн шинэ жилийн баяр(Элсэлтийн баяр)	Хичээлийн шинэ жил, 1 улирал эхлэх өдөр	3 сарын эхний ажлын өдөр
Туршлага судлах хичээл	Музей, газар тариалангийн ажилтай танилцах сургалт зэрэг танхимын бус сургалт явагдах өдөр	Сургууль тус бүрийн цагийн хуваарь ялгаатай
Спортын өдөрлөг(Биеийн тамир, спортын тэмцээн)	Сургууль, ангийн хэмжээнд биеийн тамир, спортын тэмцээн зохион байгуулах өдөр	5 болон 10 сар
Нээлттэй хичээл	Хүүхдийн хичээлд оролцож байгаа байдлыг эцэг, эхчүүдэд харуулна.	4–5 сар
Зуны амралт	1-р улирлын хичээл дуусч, зуны амралт эхлэх өдөр	7 сарын эцэс
(Зун) Шинэ хичээлийн улирал эхлэх баяр	Зуны амралт дуусаад 2-р улирлын хичээл эхлэх өдөр	8 сарын эцэс
Сургалтын хөтөлбөрийн тайлант өдөрлөг	Сурагчид сурч мэдсэн зүйлээ тайлагнах өдөр	11 сар
Өвлийн амралт	Өвлийн амралт эхлэх өдөр	12 сарын эцэс
Хичээл хаах ёслол(Төгсөлтийн баяр)	Тухайн хичээлийн жилийн хамгийн сүүлийн өдөр	12 сар–дараа жилийн 2-р сар
Сургуулиас тогтоосон амралтын өдөр	Сургуулиас бие дааж тогтоосон амралтын өдөр	Сургуулиас тогтооно
Сургуулийн ойн баярын өдөр	Сургууль үүсгэн байгуулагдсан ойн баярын өдөр	Сургуулиас тогтооно

※ Дээрхи хүснэгтэд харуулсан хичээлийн хуваарь нь жишээ бөгөөд тухайн сургуулийн үйл ажиллагаанаас хамаараад ялгаатай байна.

## ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД)-ИЙН АНГИЛАЛ, СУРГУУЛЬД ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### Цагаачилж ирсэн хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн ангилал



### Цагаачилж ирсэн хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд) сургуульд элсүүлэх журам

- Солонгос иргэншилтэй хүүхэд: Солонгост төрсөн хүүхэд буюу солонгос улсын иргэншилтэй хүүхдийг солонгос хүүхдийн нэгэн адил сурагчийн бүртгэлд хамруулах журам мөрдөнө.
- Гадаад иргэдийн дундаас төрсөн хүүхэд зэрэг гадаад улсын иргэншилтэй сурагч: Гадаад иргэдийн дундаас төрсөн, гадаад улсад амьдарч байгаад ирсэн зэрэг солонгост амьдарч, сурч байгаагүй хүүхэд сургуульд орох тохиолдолд оршин суугаа газрынхаа харьяа боловсролын газар(боловсролыг дэмжих газар)-т хандаж сургуульд элсэх журмыг лавлана уу.

	Бага сургууль	Дунд сургууль	Ахлах сургууль
① Сургуульд элсэх өргөдөл	Оршин суугаа газрынхаа харьяа нийгмийн халамжийн төвөөс лавласны дараа элсэж орох бага сургуулийн захирлын нэр дээр элсэх өргөдөл гаргана.	Оршин суугаа газрынхаа харьяа боловсролын газар, амьдарч байгаа тойрогт хамрах дунд сургуулийн захирлын нэр дээр элсэх өргөдөл гаргана.	Элсэн суралцахыг хүсч байгаа ахлах сургуулийн захирлын нэр дээр элсэх өргөдөл гаргана.
② Сургуульд элслэхэд бүрдүүлэх материалыг шалгана	※ Дэлгэрэнгүй мэдээллийг 'Сургуульд ороход бэлдэх'(8-10 хуудас) хэсгээс авна уу.		
③ Анги тогтоох арга	Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримттай бол  Гадаад улсын сургуульд сурч байсан хугацаа, сурч дүргэсэн сургалтын хөтөлбөрийг солонгос боловсролын тогтолцоо(12 жилийн сургалт)-той харьцуулан тогтооно. Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримтад тулгуурлан орох ангийг тогтооно.	Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох боломжгүй бол  Эзэмшсэн боловсролын чадварыг шалгаж, баталгаажуулсны дараа анги хуваарилна. ※ Хот, аймгийн боловсролын газрын эзэмшсэн боловсролын чадвар тогтоох хороо, Боловсролын газрын даргын итгэмжлэл хүлээсэн хүүхдийн эзэмшсэн боловсролын түвшин тогтоож, анги хуваарилах зөвшөөрөлтэй сургууль шийдвэр гаргана.	
④ Бүртгэлд тавигдах шаардлага (Сургууль)	Бүртгэл хийлгэхэд эцэг, эхийн анхаарах зүйлс · Сурагчийн овог, нэр: Гадаад паспорт(Гадаад иргэний бүртгэлийн лавлагаа, гадаад иргэний бүртгэлийн үнэмлэх г.м)-н дээр бичигдсэн овог, нэртэй адилхан байна. * Нотлох баримтан дээр англи, солонгос үсгээр галиглаж бичсэн овог нэрийг хүүхэд, эцэг эхийн хүсэлтийн дагуу галиглан бичиж болно. · Иргэний бүртгэлийн дугаар : Гадаад иргэний бүртгэлийн дугаараар бүртгүүлсэн бол оруулна. * Гадаад иргэний бүртгэлийн дугаар байхгүй бол эхний 6 оронтой тоо бичих нүдэнд төрсөн он, сар, өдрийг, арын 7 оронтой тоо бичих нүдэнд 3000000(эрэгтэй), 4000000(эмэгтэй) гэж бичнэ.		

## Цагаачилж ирсэн хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн сургалтанд үзүүлэх дэмжлэг



### Хүүхдийн боловсрол эзэмших тэгш эрхийг хангах албан сургалтанд хамрагдахад үзүүлэх дэмжлэг

- **Бага, өсвөр насны хүүхдийн оршин суух ангилал, иргэншил, үндэс угсааг үл харгалзан** бага, дунд сургуульд элсэж орох, шилжин суух боломжтой.
- Бага насны хүүхдийн боловсрол эзэмших эрхийг нь хангах үүднээс хүүхдээр нь дамилдуулан урт хугацаагаар хууль бус аргаар оршин сууж байгаа эсэхийг нь шалгахгүй.



### Сургуульд дасгах, солонгос хэл-соёлын боловсролд үзүүлэх дэмжлэг

- **Жингом-тари сургалт**
  - Бага дунд сургуульд элсэж, шилжиж орох гэж байгаа цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-д зориулсан сургуульд дасгах хөтөлбөр
- **Солонгос хэлний урьдчилсан сургалт**
  - Гадаад улсад амьдарч байгаад ирсэн солонгосоор ярьж чадахгүй сурагчдыг сургуулийн хөтөлбөрөөс гадуур сургалт явуулдаг байгууллага(итгэмжлэл хүлээсэн байгууллага)-ын солонгос хэлний эрчимт сургалтанд 3 сар-1 жилийн хугацаагаар хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.
- **Солонгос хэлний анги(Хос соёлын сургалттай тусгай анги)**
  - Солонгост ирээд удаагүй байгаа гадаадад амьдарч байгаад ирсэн-гадаад хүүхдэд зориулсан солонгос хэлний эрчимт сургалт, сургуульд дасгах тусгай сургалттай анги нээж ажиллуулна.
- **Солонгос хэлний явуулын сургалт**
  - Хичээлийн дараа солонгос хэлний багш сургууль дээр ирж солонгос хэл заана.
- **Оюутны менторинг хөтөлбөр**
  - Их сургуулийн оюутнууд(ментор) гадаад улсад амьдарч байгаад ирсэн бага насны хүүхэд, сурагчид(менти)-ыг сургуульд нь дасгаж, хичээлд нь тусална.
- **Сурах бичгийн хавсралт сурах бичиг зохиож-тараана**
  - Хүүхдийн хичээлд туслах зорилго бүхий сурах бичгийн үндсэн ухагдахуун, үгийн санг тайлбарласан сурах бичиг



### Ирээдүйд эзэмших мэргэжлийн сургалт, сэтгэл зүйд үзүүлэх дэмжлэг

- **Хос хэлний давуу талыг хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг**
  - Хос хэл сурахад дэмжлэг үзүүлэх хос хэлний сурах бичгээр хангаж, 'ХОС ХЭЛЭЭР ХЭН САЙН ЯРЬЖ ЧАДАХ ВЭ ТЭМЦЭЭН' зохион байгуулна.
- **Ирээдүйд эзэмших мэргэжлийн сургалтын хөтөлбөр, менторинг**
  - Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн онцлогт тохирсон ирээдүйд эзэмших мэргэжлийн сургалтын хөтөлбөр
  - 'Ирээдүйд эзэмших мэргэжлийн менторинг зайн сургалт(mentoring.career.go.kr)'
- **Сургуульдаа дасахад нь үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг**
  - Гадаад хэл дээр орчуулсан 'Сэтгэл зүйн байдлыг тодорхойлох тест'-ээр хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, дүүргийн харъяа Wee class, хос соёлт гэр бүлийн бага-өсвөр насны хүүхдийг дэмжих төвтэй холбоно.

# ГАРЧИГ *contents*



## PART I СУРГУУЛЬД ОРОХОД БЭЛДЭХ

- 01 Элсэлтийн журам 8
- 02 Гадаад иргэншилтэй хүүхэд сургуульд оруулахад бүрдүүлэх материал 9
- 03 Гадаад иргэншилтэй сурагчийн эзэмшсэн боловсролын түвшинг тогтоож, баталгаажуулах арга 10

## PART II АНГИ ТУС БҮРД ТАВИГДАХ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

- 01 Цэцэрлэг 12
- 02 Бага сургууль 14
- 03 Дунд сургууль 16
- 04 Ахлах сургууль 18

## PART III БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

- 01 Сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг 22
- 02 Сургууль, ахуйг дэмжих хөтөлбөр 23

## PART IV ХАВСРАЛТ

- [Хавсралт 1] Албан сургалтанд хамрагдах(сургуульд орох)-д хэрэглэгдэх нэр томъёо 25
- [Хавсралт 2] Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эцэг, эхчүүдэд зориулсан бичлэг 25
- [Хавсралт 3] Солонгос хэлний төлбөргүй сургалт явуулдаг вэб сайт 26
- [Хавсралт 4] Сургуулийн элсэлтийн журам, сургуулийн үйл ажиллагааны тухай зөвлөгөө өгөх төв 27



PART I



## СУРГУУЛЬД ОРОХОД ЭЛДЭХ



1. Элсэлтийн журам
2. Гадаад иргэншилтэй хүүхэд сургуульд оруулахад бүрдүүлэх материал
3. Гадаад иргэншилтэй сурагчийн эзэмшсэн боловсролын түвшинг тогтоож, баталгаажуулах арга

## I

## СУРГУУЛЬД ОРОХОД БЭЛДЭХ

## 1. Элсэлтийн журам

## Сургуульд элсэж ороход тавигдах иргэний харъяаллын ангилал

Ангилал	 Солонгос иргэншил	 Гадаад иргэншил
Хамрах хүрээ	Солонгос иргэншилтэй бага насны хүүхэд (Давхар иргэншил багтана)	Гадаад иргэншилтэй бага насны хүүхэд (Бүртгэлгүй, цагаачилж ирсэн бага насны хүүхэд, дүрвэгч багтана)
Агуулга	Цагаач бус хүүхэдтэй нэгэн адил аргаар сурагчийн бүртгэлд хамруулна.	Гадаад иргэншилтэй хүүхэд сургуульд элсүүлэх журмыг баримтлана.

## Сургуульд элсэж орох өргөдөл



※ Хүүхдийнхээ элсэж, шилжиж орох сургуулийг сонгохын өмнө оршин суугаа газрынхаа харъяа сургууль, хот, аймгийн боловсролын төвөөс зөвлөгөө авна(Хавсралтыг үзнэ үү).

Ангилал	 Солонгос иргэншил	 Гадаад иргэншил
	Солонгос улсын давхар иргэншилтэй бол	Бүртгэлгүй, цагаач, дүрвэж ирсэн хүүхэд
 Цэцэрлэг	<ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэг, яслийн хүүхэд бүртгэх 'Ясли, цэцэрлэгийн цахим бүртгэлийн нэгдсэн систем(enter.childinfo.go.kr)'-ээр дамжуулан хүсэлт гаргана. (11 сарын 1-нд бүртгүүлсэн дарааллаар бүртгэл явагдсаны дараа 11 сараас хойш бага насны хүүхдийн бүртгэл явагдана)</li> <li>- Цэцэрлэгийн даргын нэр дээр хүсэлт гаргана(байнга)</li> </ul> <p>※ Жич: Хүүхдийн орон тоог харгалзан бүртгэнэ.</p>	
 Бага сургууль	<ul style="list-style-type: none"> <li>- Захиргааны халамжийн төв зэрэг төрийн байгууллагаас гэрийн хаягаар хүүхэд сургуульд орох насанд хүрсэн тухай мэдэгдэл илгээнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Оршин суугаа газрын харъяа хамран сургах тойрогт багтах бага сургуулийн захирлын нэр дээр өргөдөл гаргана.</li> </ul> <p>※ Оршин суугаа газрын харъяа өб-мён-хороо захиргааны халамжийн төвөөс лавласны дараа хүсэлт гаргана.</p>
 Дунд сургууль	<ul style="list-style-type: none"> <li>- Сурч байгаа бага сургуулиас нь элсэх өргөдөл гаргаж, дунд сургуульд хуваарилна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Оршин суугаа газрынхаа харъяа боловсролын газар, амьдарч байгаа тойрогт хамрах дунд сургуулийн захирлын нэр дээр элсэх өргөдөл гаргана.</li> </ul>
 Ахлах сургууль	<ul style="list-style-type: none"> <li>- Сурч байгаа дунд сургуулиас нь элсэх өргөдөл гаргаж, ахлах сургуульд хуваарилна.</li> </ul> <p>※ Ахлах сургуулийн элсэлтийн мэдээллийн цахим хуудас(www.hischool.go.kr)-наас өөрөө шалгана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Элсэн суралцахыг хүсч байгаа ахлах сургуулийн захирлын нэр дээр элсэх өргөдөл гаргана.</li> </ul> <p>※ Элсэлтийн журмын тусгай заалтын дагуу элсэх өргөдөл гаргаж байгаа тохиолдолд элсэх боломжтой эсэхийг тухайн сургууль, боловсролын газраас урьдчилан лавлана.</p>

## 2. Гадаад иргэншилтэй хүүхэд сургуульд оруулахад бүрдүүлэх материал






### Цэцэрлэг

Ангилал	Агуулга
 Нэгдүгээр ангид орох, сургууль шилжиж суух өргөдөл	- Орох гэж байгаа сургууль, боловсролын төвийн маягт
 Цагаачлалын албаны лавлагаа, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа	- Цагаачлалын албаны лавлагаа, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа(Аль нэгийг нь бүрдүүлж өгнө) ※ Цагаачлалын алба, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа гаргуулах боломжгүй тохиолдолд <b>байрны түрээсийн гэрээ, оршин суудаг гэдгийг нотлох хувийн баталгаажуулсан бичиг(баталгаа гаргасан хүний тодорхойлолт)-ээр амьдардаг нь үнэн гэдгийг нотлох баримтаар</b> орлуулж болно.

### Бага-дунд-ахлах сургууль



Ангилал	Агуулга
 Нэгдүгээр ангид орох, сургууль шилжиж суух өргөдөл	- Орох гэж байгаа сургууль, боловсролын төвийн маягт
 Цагаачлалын албаны лавлагаа, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа	- Цагаачлалын албаны лавлагаа, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа(Аль нэгийг нь бүрдүүлж өгнө) ※ Цагаачлалын алба, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа гаргуулах боломжгүй тохиолдолд <b>байрны түрээсийн гэрээ, оршин суудаг гэдгийг нотлох хувийн баталгаажуулсан бичиг(баталгаа гаргасан хүний тодорхойлолт)-ээр амьдардаг нь үнэн гэдгийг нотлох баримтаар</b> орлуулж болно.
 Эзэмшсэн боловсролын түвшин тогтоох баримт (Сургууль төгссөн гэрчилгээ, сурч байсан сургуулийн тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт)	- Сургуульд орсон, сургуулиас гарсан он/сар/өдөр, сурч байсан ангийг тодруулах боломжтой сургуулийн захирлын гарын үсэг, тамгатай бичиг баримт, сертификатыг, сурлагын дүнгийн хуудас ※ Эзэмшсэн боловсролын түвшин тогтоох боломжгүй бол <b>‘Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эзэмшсэн боловсролын түвшин тогтоох хороо’</b> тогтооно.
 Сургуулийн сурагчийн хувийн хэрэг(гаргуулах боломжтой хүүхэд)	- Солонгост сургуульд сурч байсан хүүхэд бүрдүүлнэ.
 Вакцинжуулалтын гэрчилгээ	- ‘Хүүхдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх онцгой байдлын үед арга хэмжээ авах заавар’-ын ‘Гадаад улсаас ирсэн хүүхдийн вакцинжуулалтад тавих хяналт’-д заасны дагуу холбогдох материал бүрдүүлж өгөхийг сургуулиас шаардаж болно.
 Аймаг, хотын боловсролын төвийн гарын авлагад заасан материал	- Харьяа боловсролын төвөөс бүрдүүлэх баримтыг заавал шалгана.

※ Өөрөө зөвшөөрсөн тохиолдолд иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй-хураангуй хуулбар, гадаад иргэний бүртгэлийн лавлагаа сургууль, боловсролыг дэмжих төвөөс шүүлгэх боломжтой. Үүнээс бусад хүүхдийн боловсрол эзэмших асуудалтай холбогдуулан сурагчийн хувийн мэдээлэл шалгах зорилгоор сургуулиас паспортны хуулбар, ам бүлийн лавлагаа, иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй хуулбар(Солонгос иргэншилд орсон тохиолдолд) зэрэг баримт бүрдүүлж өгөхийг шаардана.



**Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эзэмшсэн боловсролын түвшин тогтоох хороо**

Эзэмшсэн боловсролын түвшин тогтоох боломжгүй тохиолдолд эзэмшсэн боловсролын түвшин, анги хуваарилах асуудлыг шийдэх хороо

- Эзэмшсэн боловсролын түвшинг баталгаажуулах: Бага, дунд сургууль төгсөж эзэмшсэн боловсролын түвшинг тогтоож баталгаажуулахыг хэлнэ.

- Анги хуваарилах шийдвэр: Элсэж орох анги, хичээлийн жил, улирал тогтоохыг хэлнэ.



### 3. Гадаад иргэншилтэй сурагчийн эзэмшсэн боловсролын түвшинг тогтоож, баталгаажуулах арга(1-ийг нь сонгоно)

Ангилал	Шалгах арга
① Боловсролын яамны вэб сайтаас шалгана	Боловсролын яамны сайты(www.moe.go.kr) нүүр хуудас→[Бодлого]→[Бага-дунд-ахлах сургуулийн боловсрол] цэснээс шалгана. ※Боловсролын яамнаас сургалтыг нь хүлээн зөвшөөрсөн сургуулийн захирлын гаргасан тодорхойлолтыг аподистил болон консулын газрын баталгаагүйгээр хүлээн зөвшөөрнө.
② Апостилийн гэрчилгээ (Гадаад харилцааны яам, Хууль зүйн яамны баталгаажуулалт)	Гадаад харилцааны яамны харъяа Гадаад улсад аюулгүй зорчих сайт(www.0404.go.kr)-ны нүүр хуудас → Консолын үйлчилгээ цэсийг шалгана.
③ Консулын газрын баталгаа	“Монгол улсад албан ёсны сургалт явуулдаг сургууль” гэдгийг тодорхойлж БНСУ-аас Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газраас гаргасан баримтыг шалгана.
④ Бусад тохиолдолд	Тухайн улсын боловсрол олгох албан ёсны байгууллага(оршин суугаа улсын харъяа боловсролын газраас явуулж байгаа сургалтыг нь хүлээн зөвшөөрсөн сургууль) гэсэн тайлбар



**Анхаар! - Бүрдүүлэх баримт гаргуулж авах газар**

Бүрдүүлэх материал	Олгох байгууллага
Сургуульд орох(шилжиж орох) өргөдөл	- Элсэж орох сургууль, харъяа боловсролын төвөөс авна
Цагаачлалын албаны лавлагаа	- Хот-сум-дүүргийн тамгын газар, өб-мөнь-хорооны халамжийн төв, цагаачлалын алба
Гадаад иргэний бүртгэлийн лавлагаа	
Солонгост оршин суугаа газрын бүртгэлийн лавлагаа	
Иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй-товч лавлагаа (Солонгос иргэншилтэй хүнд хамаарна)	- Хот-сум-дүүргийн тамгын газар, өб-мөнь-хорооны халамжийн төв
Өрхийн ам бүлийн тодорхойлолт, төрсний гэрчилгээ	

※ Төрөл бүрийн лавлагааг Захиргаа 24(www.gov.kr) сайтаар дамжуулан онлайнаар гаргуулж авах боломжтой.

PART II



## АНГИ ТУС БҮРД ТАВИГДАХ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

1. Цэцэрлэг
2. Бага сургууль
3. Дунд сургууль
4. Ахлах сургууль

## II

## АНГИ ТУС БҮРД ТАВИГДАХ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

## 1. Цэцэрлэг



## Ангилал

- **Улсын цэцэрлэг** : Төрийн өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг
- **Хот, аймгийн цэцэрлэг** : Орон нутгийн захиргааны байгууллагын өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг
- **Хувийн цэцэрлэг** : Хуулийн этгээд, хувь хүн өөрийн өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг.

## Элсэлт авах хугацаа

- 3 насны төрсөн өдөр багтсан оны дараа жилийн 3 сарын 1-нээс хойш цэцэрлэгт орно.
- Албан ёсны бүртгэл: 10-11 сарын дундуур **цэцэрлэгийн хүүхэд бүртгэх нэгдсэн систем 'Цэцэрлэгийн лсэлтийн бүртгэлийн цахим хуудас(enter.childinfo.go.kr)'**-аар дамжуулан өргөдөл гаргана
- Байнгын элсэлт : Албан ёсны бүртгэлийн хугацаа дууссанаас хойш насыг нь харгалзан үлдсэн орон тооноос хэтрүүлэхгүйгээр байнга бүртгэнэ. Цэцэрлэг дээр бүртгэх боломжтой эсэхийг тухайн цэцэрлэгээс лавлана уу.
- ※ Албан ёсны бүртгэлийн хугацаа дууссанаас хойш цэцэрлэгт орох өргөдлийг тухайн цэцэрлэгт гаргаж өгнө. Цэцэрлэгийн ангийн орон тоо үлдсэн бол элсүүлэх боломжтой.

## Элсэх журам

## Нэгдүгээр ээлжийн бүртгэл\*

Өргөдөл хүлээж авна

Сугалаа-зарлана

Бүртгэл

## Энгийн бүртгэл

Урьдчилсан бүртгэл

Үндсэн бүртгэл

Сугалаа-зарлана

Бүртгэл

Хүлээгдэж байгаа хүүхдийн нэрсийн жагсаалт гаргана

## Нэмэлт бүртгэл

Бүртгэл явагдана

\*Нэгдүгээр ээлжийн бүртгэл: Түрүүлж элсүүлэх хүүхэд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгахын тулд цэцэрлэгийн хүүхэд элсүүлэх журамд заасан баримтыг бүрдүүлж өгнө.

## Элсэх өргөдөл Цахим хуудсаар үйлчлүүлэх журам



## Цэцэрлэгийн сургалтын хуваарь

- **Хөтөлбөрийн хуваарь**: Нүри сургалтын хөтөлбөр(1 өдөрт 4-5 цаг), хичээлийн дараахи сургалт(сургалтын хөтөлбөрийн дараа) явагдана. Сургалтын хөтөлбөрийн хуваарь нь тухайн цэцэрлэгийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад ялгаатай байдаг.

&lt;Нэг өдрийн сургалтын жишээ&gt;

Ангилал	Цаг	Агуулга
Нүри сургалтын хөтөлбөр	09:00-13:00	Цэцэрлэг дээр ирнэ, чөлөөтэй тоглоно, хөнгөн цай, гадаа гарч тоглоно, өдрийн хоол, сургалтын хөтөлбөр
Сургалтын хөтөлбөрийн дараахи хөтөлбөр	13:00-18:00	Амралтын цаг, өдрийн унтлага, өдрийн хөнгөн цай, тусгай хөтөлбөр, тусгай сургалтын хичээл, чөлөөтэй тоглоно, гадаа гарч тоглоно

**Ясли, цэцэрлэгийн  
төлбөрийн  
тэтгэлэг**

(2025.3.1 -ний байдлаар)



※ Тэтгэлгийн мөнгөн дүн хот, аймгаас хамаараад ялгаатай байдаг тул харъяа боловсролын газар(боловсролыг дэмжих газар), өб, мёнъ, хороо захиргааны халамжийн төвөөс лавлана уу.

· Өрхийн орлогын хэмжээг үл харгалзан 3-5 насны бүх хүүхдэд ясли, цэцэрлэгийн төлбөрийн тэтгэлэг олгодог.

※ Жич: Тэтгэлгийг зөвхөн 3 жил олгоно.

· Дээрхи хүснэгтэд тавьсан шаардлагыг хангасан бөгөөд хувийн өмчийн цэцэрлэгт явж байгаа бага орлоготой өрх(амьжиргааны доод түвшинг баталгаажуулах тэтгэмжид хамрагддаг, доогуур орлоготой өрх, ганц бие эцэг, эх)-ийн хүүхдэд сар тутам 200,000 воноос хэтрэхгүй нэмэлт тэтгэлэг олгоно.

\* Ясли, цэцэрлэгт эрт явж эхэлсэн, сургуульд орох насыг нь хойшлуулсан тохиолдолд тэтгэлэгт хамрагдана.

· Хүүхдийн эцэг, эх(асран хамгаалагч)-ийн оршин суугаа газрын харъяа өб-мёнъ-хороо захиргааны халамжийн төв дээр өөрийн биеэр очиж болон Бугжиру([www.bokjigo.go.kr](http://www.bokjigo.go.kr)) цахим хуудсаар дамжуулан хүсэлт гаргана





## 2. Бага сургууль

### Ангилал


- **Улсын бага сургууль:** Төрийн өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулж байгаа бага сургууль, боловсролын их сургууль, улсын их сургууль, багшийн дээд сургуулийн харьяа бага сургууль
- **Хотын бага сургууль:** Аймаг, хотын өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулж байгаа бага сургууль
- **Хувийн бага сургууль:** Хуулийн этгээд, хувь хүн өөрийн өмчөөр байгуулан, үйл ажиллагаа явуулж байгаа бага сургууль

### Элсэлт авах хугацаа

- Хүүхдийн 6 нас хүрсэн жилийн дараа жилийн 3 сарын 1-нд сургуульд орно.
- Ихэвчлэн захиргааны халамжийн төвөөс илгээсэн “Хүүхэд сургуульд орох насанд хүрсэн тухай мэдэгдлийн хуудас”-н дээр нэр зааж хуваарилсан сургуульд элсэж ордог.
- Хүүхдээ сургуульд орох наснаас нь өмнө болон хойно сургуульд оруулах хүсэлтэй эцэг эхчүүд **10 сарын 1-нээс 12 сарын 31-ний хооронд** оршин суугаа газрынхаа харъяа өб-мөнх-хороо захиргааны халамжийн төв дээр ирж өргөдөл гаргах боломжтой бөгөөд сайтар тунгааж бодсоны дараа шийдвэр гаргана уу.

※ Солонгос улсын иргэний харъяалалтай хүүхдийг бага сургуульд оруулаагүй бол торгууль ногдуулна.

### Элсэх журам



### Сургуульд орох хүүхэд тус бүрийн бэлдэх зүйлс

- **Солонгос иргэншилтэй хүүхэд**
  - Солонгост төрсөн хүүхэд буюу солонгос улсын иргэншилтэй хүүхдийг солонгос хүүхдийн нэгэн адил сурагчийн бүртгэлд хамруулах журам мөрдөнө.
  - Ихэвчлэн оршин суугаа газрыг харгалзан сургуульд хуваарилдаг боловч хос соёлт гэр бүлийн солонгос хэл сайн мэдэхгүй хүүхдийг хос соёлын тусгай сургалт(Солонгос хэлний анги)-тай бага сургуульд оруулах боломжтой.
- **Гадаад улсын иргэншилтэй хүүхэд**
  - Солонгост төрсөн **гадаад гэр бүлийн хүүхдийн** нэр дээр сургуульд орох насанд хүрснийг мэдэгдэх хуудас очихгүй тул **солонгост амьдарч байгаа гэдгийг нотлох баримт бүрдүүлэн өб-мөнх-хороо захиргааны халамжийн төв юмуу ойрхон бага сургууль дээр очиж хүүхэд сургуульд оруулах талаар зөвлөгөө авна уу.**
  - **Бүртгэлгүй гадаад иргэдийн хүүхэд ч гэсэн нэгдүгээр ангид орох боломжтой** тул цагаачлалын албаны тодорхойлолт гаргуулах боломжгүй бол байрны түрээсийн гэрээ, батлан даалт(хувийн батлан даалт)-ын бичиг **зэрэг солонгост амьдардаг** гэдгийг нотлох баримт, **төрсөн он сар өдрийг** тодруулах боломжтой баримтыг бүрдүүлж өгнө.



### Гадаад улсад амьдарч байгаад ирсэн тохиолдолд

- Оршин суугаа газрынхаа харъяа боловсролын газар, орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвд хандаж хүүхэд сургуульд орох тухай зөвлөгөө авна(Хавсралт 27-г үзнэ үү)
- Солонгост оршин суугаа газрын лавлагаа, эзэмшсэн боловсролын түвшинг нотлох(элсэж орох анги тогтоох зорилгоор) баримт  
(“Сургуульд ороход бэлдэх” хэсгийн 8-10 дугаар хуудсыг үзнэ үү)
- ※ Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох боломжгүй тохиолдолд эзэмшсэн боловсролын түвшин тогтоох байгууллагад хандан өргөдөл гаргаж орох ангийг тогтоолгоно(Хот, аймгаас хамаараад хариуцсан хэлтэс нь ялгаатай байдаг тул орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвөөс лавлана уу.)

### Бага сургуулийн хөтөлбөр

- **Хичээлийн хөтөлбөр** ※ Дэлгэрэнгүй мэдээллийг ‘Эцэг, эхийн дэвтэр’-ээс авна уу.
  - Сургалтын хөтөлбөрийн дагуу орох **1 цагийн хичээл 40 минут үргэлжилж, 10 минут завсарлана**
  - 1 өдөр 4 – 6 цагийн хичээл орно.
  - Хичээлийн нэр
    - Бага сургуулийн 1-2 дугаар анги: Эх хэл, тоо, нэгдсэн сургалтын хөтөлбөр
    - Бага сургуулийн 3-4 дугаар анги: Эх хэл, нийгэм, ёс суртахуун, тоо, шинжлэх ухаан, биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлаг, англи хэл
    - Бага сургуулийн 5-6 дугаар анги: Эх хэл, нийгэм, ёс суртахуун, тоо, шинжлэх ухаан, биеийн тамир, дадлагын хичээл, дуу хөгжим, дүрслэх урлаг, англи хэл
- **Нель-бум сургалтын хөтөлбөр**
  - **Нельбум дамжаа** гэж юу вэ? Албан ёсны хичээл дууссаны дараа **явагддаг сургалтын хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан сурагчдыг хамруулах сургалтын хөтөлбөр**
    - Хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих зорилгоор биеийн тамир, урлаг, ирээдүйд эзэмших мэргэжилтэй холбоотой төрөл бүрийн хөтөлбөр зохион байгуулдаг.
    - Сурахыг хүссэн бүх сурагчид хамрагдах боломжтой. Бага сургуулийн 1-2 дугаар ангийн сурагчдын түвшинд тохирсон төлбөргүй сургалтын хөтөлбөр өдөр бүр 2 цаг явагдана.

※ Тухайн сургуулийн нөхцөл байдлаас хамаараад өглөөний Нельбум сургалт, Төмсэ-Нельбум зэрэг төрөл бүрийн сургалт зохион байгуулагддаг тул Нельбум сургуулийн сургалтанд хамрагдах өргөдөл гаргахаасаа өмнө харъяа боловсролыг дэмжих газар, сургуулиасаа лавлаж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.



### 3. Дунд сургууль

#### Ангилал

Энгийн дунд сургууль		Улсын боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол олгох энгийн сургалт явуулдаг дунд сургууль. Дунд сургуулиудын ихэнх хувийг эзэлдэг.
Техник мэргэжлийн сургалттай дунд сургууль	Урлаг, биеийн тамирын дунд сургууль	Урлаг, биеийн тамирын техник мэргэжлийн дунд сургууль
	Олон улсын дунд сургууль	Даяарчлалын эринд нийцсэн олон улсын боловсон хүчин бэлтгэх дунд сургууль
	Орлуулах дунд сургууль	Практик сургалтад суурилсан орлуулах сургалт явуулдаг техник мэргэжлийн дунд сургууль

- ※ Сургууль байгуулсан газрыг харгалзан улсын, хотын, хувийн сургууль гэж ангилна.
  - Улсын сургууль: Улсаас байгуулан үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина.
  - Хот, аймгийн сургууль: Хот, аймгийн захиргаанаас байгуулан үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина.
  - Хувийн сургууль: Хувь хүн, хуулийн этгээд байгуулан үйл ажиллагааг нь удирдаж, хяналт тавина.


#### Элсэлтийн хугацаа

- Ихэвчлэн 12 нас хүрэх жил бага сургуулиа төгсөөд ахлах сургуульд элсэж ордог (**Бага сургууль төгссөн юмуу үүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэн гэдэг нь батлагдсан хүүхэд** заавал дунд сургуульд элсэн суралцах үүрэг хүлээнэ)

- ※ Солонгос улсын иргэний харъяалалтай хүүхдээ дунд сургуульд оруулаагүй бол торгууль ногдуулна.

- Техник мэргэжлийн тусгай сургалттай дунд сургуулиудын элсэлтийн хуваарь (элсэлт авах хугацаа, элсэлтийн журам гэх мэт) хоорондоо ялгаатай байдаг тул урьдчилан лавлаж асуусны дараа өргөдөл гаргана уу.

#### Элсэх журам



#### Сургуульд орох хүүхэд тус бүрийн бэлдэх зүйлс

- Солонгос иргэншилтэй хүүхэд
  - Солонгост төрсөн хүүхэд буюу солонгос улсын иргэншилтэй хүүхдийг солонгос хүүхдийн нэгэн адил сурагчийн бүртгэлд хамруулах журам мөрдөнө.

- Бага сургуулийн 6 дугаар ангийн 2-р улиралд оршин суугаа газрынхаа харъяа(10 сарын 31-ний байдлаар гэрийн хаяг) хамран сургах тойрогт хамаарах дунд сургуульд хуваарилахыг хүссэн өргөдлийн дагуу хамгийн ойрхон дунд сургуульд сугалаагаар хуваарилна.
- **Гадаад улсад амьдарч байгаад ирсэн хүүхэд хос соёлын тусгай сургалт(солонгос хэлний анги)-тай дунд сургуульд орж болно.**
- **Гадаад улсын иргэншилтэй хүүхэд**
  - Гадаад иргэншилтэй хүүхэд дунд сургуулийн 1 дүгээр ангид элсэж орох(шинэ элсэгч) тохиолдолд солонгос хүүхэд сургуульд элсэх хэлтэс, **оршин суугаа газрынхаа харъяа боловсролыг дэмжих газар юмуу ойрхон дунд сургуульд хандаж элсэх боломжтой эсэхийг шалгана.**
  - **Бүртгэлгүй гадаад иргэдийн хүүхэд ч гэсэн нэгдүгээр ангид орох боломжтой** тул цагаачлалын албаны тодорхойлолт гаргуулах боломжгүй бол байрны түрээсийн гэрээ, батлан даалт(хувийн батлан даалт)-ын бичиг зэрэг **солонгост амьдардаг гэдгийг** нотлох баримт, **төрсөн он сар өдрийг** тодруулах боломжтой баримтыг бүрдүүлж өгнө.



#### **Гадаад улсад амьдарч байгаад ирсэн тохиолдолд**

- Оршин суугаа газрынхаа харъяа боловсролын газар, орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвд хандаж хүүхэд сургуульд орох тухай зөвлөгөө авна(Хавсралт 27-г үзнэ үү)
- Солонгост оршин суугаа газрын лавлагаа, эзэмшсэн боловсролын түвшинг нотлох(элсэж орох анги тогтоох зорилгоор) баримт  
(“Сургуульд ороход бэлдэх” хэсгийн 8-10 дугаар хуудсыг үзнэ үү)
- ※ Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох боломжгүй тохиолдолд эзэмшсэн боловсролын түвшин тогтоох байгууллагад хандан өргөдөл гаргаж орох ангийг тогтооно(Хот, аймгаас хамаараад хариуцсан хэлтэс нь ялгаатай байдаг тул орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвөөс лавлана уу.)

#### **Дунд сургуулийн үйл ажиллагаа**

- **Хичээлийн хөтөлбөр** ※ Дэлгэрэнгүй мэдээллийг “Эцэг, эхийн дэвтэр”-ээс авна уу.
  - Бага сургуулийн хичээлийг анги даасан багш, **дунд сургуулийн хичээлийг [анги даасан багш + мэргэжлийн багш]** заана.
  - **1 цагийн хичээл 45 минут үргэлжилж, 10 минут завсарлана.** 1 өдөр 6 – 7 цагийн хичээл орно.
- **Хичээлээ чөлөөтэй сонгож үзэх улирлын тогтолцоо**
  - **Хичээлээ чөлөөтэй сонгож үзэх улирлын тогтолцоо** гэж юу вэ? Дунд сургуулийн нэг улиралд сурагчдыг шалгалтны дарамтнаас салгаж, төрөл бүрийн туршлага судлах хөтөлбөрт хамруулан хүүхэд өөрийн онцлогт тохирсон, ирээдүйд эзэмших мэргэжлээ хайж олоход нь дэмжлэг үзүүлдэг тогтолцоо.
  - Явцын болон улирлын эцсийн бичгийн шалгалт авахгүйгээр сурагчдын хичээлд оролцож байгаа байдал, хөгжил дэвшлийг нь харгалзан хичээлд оролцож байгаа байдлаар нь үнэлдэг.
  - Биеийн тамир-урлаг, ирээдүйд эзэмших мэргэжил хайж олох, дугуйлан зэрэг төрөл бүрийн хөтөлбөрөөр дамжуулан сурах хүсэл төрүүлж, бие даан суралцах чадварыг дээшлүүлнэ.



## 4. Ахлах сургууль

### Ангилал

Ангилал	Агуулга		Элсэлт авах журам	
Энгийн сургалттай ахлах сургууль	Улсын боловсрол олгох хөтөлбөрийн дагуу боловсрол олгох энгийн сургалт явуулдаг ахлах сургууль. Ахлах сургуулиудын ихэнх хувийг эзэлдэг.		<ul style="list-style-type: none"> <li>- Тэгш хуваарилах бүс: Сугалаагаар хуваарилна.</li> <li>- Тэгш хуваарилах бүсэд хамрахгүй бүс: Элсэх хүсэлт гаргасан сурагчдын сурлагын дүнгээр сонгон шалгаруулна.</li> </ul>	
Гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль	Гадаад хэл, олон улс судлал, байгалийн шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль	Гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль	Гадаад хэлний өндөр чадвартай боловсон хүчин бэлтгэн гаргана	<ul style="list-style-type: none"> <li>- Сургууль тус бүрийн элсэлтийн комиссын бие даан сургах хэлбэр</li> <li>- Тухайн сургуулийн элсэлтийн журмын дагуу сурлагын дүн, ярилцлага, бичгийн шалгалтын дүнг харгалзан сонгон шалгаруулна.</li> </ul>
		Олон улсын ахлах сургууль	Олон улсын улс төр, дипломат боловсон хүчин бэлтгэн гаргана	
		Байгалийн шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль	Байгалийн шинжлэх ухааны салбарын боловсон хүчин бэлтгэн гаргана	
		Урлаг-биеийн тамирын ахлах сургууль	Уран зохиол, хөгжим, уран зураг, бүжиг, театр, кино урлагийн салбарын боловсон хүчин бэлтгэн гаргана	
		Мейстер ахлах сургууль	Ирээдүйтэй үйлдвэрлэлийн салбарын хэргэцээг хангасан залуу мэргэжилтэн(Young Meister) бэлтгэн гаргана	
Техник мэргэжлийн ахлах сургууль	Хүүхдийн авъяас, чадварт тохируулан тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн гаргах зорилгоор онол, практикт суурилсан мэргэжлийн сургалт явуулдаг ахлах сургууль.	ТМС(мэргэжил)	Сургуулиа төгсөөд ажилд орох хүсэлтэй сурагчдыг хамруулдаг мэргэжлийн сургалт	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн сургуулийн элсэлтийн журмын дагуу сурлагын дүн, ярилцлага, бичгийн шалгалтын дүнг харгалзан сонгон шалгаруулна.</li> </ul>
		ТМС(орлуулах)	Хүүхэд төвтэй бие даасан сургалт явуулдаг орлуулах сургалт	
Бие даасан сургалттай ахлах сургууль	Сургуулийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг бие даан явуулах зөвшөөрлийн дагуу бусад ахлах сургуулиас ялгаатай үйл ажиллагаа явуулдаг улсын болон хувийн өмчийн ахлах сургууль	Хувийн өмчийн бие даасан сургалттай ахлах сургууль сургалттай ахлах сургууль	Сургуулийн хэтийн зорилгын дагуу сургалт, үйл ажиллагаа явуулна	<ul style="list-style-type: none"> <li>- Тэгш хуваарилах бүс: Сугалаагаар хуваарилна.</li> <li>- Тэгш хуваарилах бүсэд хамрахгүй бүс: Элсэх хүсэлт гаргасан сурагчдын сурлагын дүнгээр сонгон шалгаруулна.</li> <li>- Санал болгож, хуваарилна</li> <li>- Сонгон шалгаруулах комиссын шалгалт</li> </ul>
		Улсын өмчийн бие даасан сургалттай ахлах сургууль	Боловсролын тогтолцоог сайжруулж, хөгжүүлэх зорилгын хүрээнд боловсролын газрын даргын зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, сургалт хөтөлбөрийг бие даан зохион байгуулна	

※ Сургууль байгуулсан газрыг харгалзан улсын, хотын, хувийн сургууль гэж ангилна.

- Улсын сургууль: Улсаас байгуулан үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина.

- Хот, аймгийн сургууль: Хот, аймгийн захиргаанаас байгуулан үйл ажиллагааг удирдаж, хяналт тавина.

- Хувийн сургууль: Хувь хүн, хуулийн этгээд байгуулан үйл ажиллагааг нь удирдаж, хяналт тавиан

### Элсэлтийн хугацаа

- Дунд сургууль төгссөн юмуу үүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэн гэдгийг нотлох шалгалтанд тэнцсэн тохиолдолд элсэн суралцах боломжтой.
- Хот, аймгийн боловсролын төвөөс гаргасан элсэлт авах хугацаа, элсэлтийн журам хоорондоо ялгаатай байдаг тул сайн лавлаж тодруулсны дараа хүсэлт гаргана уу.

### Элсэлтийн журам

- Ахлах сургуулиуд элсэлтэнд бүртгэсэн сурагчдыг сонгон шалгаруулалтаар шалгаруулж авдаг талаараа бага, дунд сургуулийн элсэлтээс ялгаатай байдаг тул урьдчилан лавлана уу.
- Ахлах сургуульд элсэгчдийг нэг, хоёрдугаар ээлжээр сонгон шалгаруулж авна
  - **Нэгдүгээр ээлжийн сонгон шалгаруулалт:** Энгийн сургалттай ахлах сургууль(Урлаг-биеийн тамир), гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль(Байгалийн шинжлэх ухаан/урлаг/биеийн тамир, аж үйлдвэрийн салбарын хэрэгцээг хангах сургалттай ахлах сургууль)
  - **Хоёрдугаар ээлжийн сонгон шалгаруулалт:** Нэгдүгээр ээлжийн сонгон шалгаруулалтанд хамрагдаагүй бүх энгийн сургалттай ахлах сургууль(урлаг-биеийн тамираас бусад ахлах сургууль)
- Ахлах сургуулийн элсэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг 'Ахлах сургуулийн элсэлтийн цахим хуудас([www.hischool.go.kr](http://www.hischool.go.kr))'-наас авна уу.

※ 'Техник мэргэжлийн ахлах сургууль-Майстер ахлах сургуулийн цахим хуудас([www.hifive.go.kr](http://www.hifive.go.kr))' болон хот, аймгийн боловсролын газрын мэргэжлийн сургалттай ахлах сургуульд элсэх заавар бүхий цахим хуудаснаас авна уу.

### Сургуульд орох хүүхэд тус бүрийн бэлдэх зүйлс

- **Солонгос иргэншилтэй хүүхэд**
  - Солонгост төрсөн хүүхэд буюу солонгос улсын иргэншилтэй хүүхдийг солонгос хүүхдийн нэгэн адил сурагчийн бүртгэлд хамруулах журам мөрдөнө.
  - Элсэлт авах хугацаа, элсэлтийн журам нь хот-аймгийн боловсролын төвөөс хамаараад ялгаатай байдаг тул урьдчилан шалгасны дараа өргөдөл гаргана уу.
- **Гадаад улсын иргэншилтэй хүүхэд**
  - **Бүртгэлгүй гадаад иргэдийн хүүхэд ч гэсэн сургуульд орох боломжтой** байдаг тул цагаачлалын албаны лавлагаа гаргуулах боломжгүй тохиолдолд байрны түрээсийн гэрээ, батлан даалт(хувийн батлан даалт)-ын бичиг **зэрэг солонгост амьдарч байгаа** гэдгийг нотлох баримт болон **төрсөн он сар өдрийг** тодруулах баримтыг бүрдүүлж өгнө.




### Гадаад улсад амьдарч байгаад ирсэн тохиолдолд


- Оршин суугаа газрынхаа харъяа боловсролын газар, орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвд хандаж хүүхэд сургуульд орох тухай зөвлөгөө авна(Хавсралт 27-г үзнэ үү)
- Солонгост оршин суугаа газрын лавлагаа, эзэмшсэн боловсролын түвшинг нотлох(элсэж орох анги тогтоох зорилгоор) баримт  
(“Сургуульд ороход бэлдэх” хэсгийн 8–10 дугаар хуудсыг үзнэ үү)
- ※ Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох боломжгүй тохиолдолд эзэмшсэн боловсролын түвшинг тогтоох байгууллагад хандан өргөдөл гаргаж орох ангийг тогтоолгоно(Хот, аймгаас хамаараад хариуцсан хэлтэс нь ялгаатай байдаг тул орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төвөөс лавлана уу.)

### Ахлах сургуулийн үйл ажиллагаа

- **Хичээлийн хөтөлбөр**
  - **Ахлах сургуулийн кредит үнэлгээний тогтолцоо болон [Анги даасан багш + Хичээл орох багш]** гэсэн тогтолцоо нь дунд сургуулиас ялгаатай байдаг.
  - **1 цагийн хичээл 50 минут үргэлжилж, 10 минут завсарлана.** 1 өдөр 6–7 цагийн хичээл орно.
- **Ахлах сургуулийн кредит үнэлгээний тогтолцоо**
  - **Ахлах сургуулийн кредит үнэлгээний тогтолцоо** гэж юу вэ? Сурагчид эзэмшсэн суурь мэдлэг болон эзэмшсэн боловсролд тулгуурлан ирээдүйд эзэмших мэргэжил, хувийн ур чадварт тохируулан хичээлээ сонгож, төгсөхөд тавигдах шаардлагыг хангасан хичээлийн кредит оноог цуглуулж-хуримтлуулан төгсөх систем
  - Сурагчид заавал үзэх хичээлээс гадна өөрийн ирээдүйд эзэмших мэргэжил, хоббид тохирсон хичээл сонгон хамрагдаж болно.
  - Сургууль төгсөхөд шаардлагатай кредит дүнг заавал цуглуулна. Энгийн бичгийн шалгалтнаас гадна явцын үнэлгээ зэрэг төрөл бүрийн аргаар сурагчдад үнэлгээ өгдөг.



PART III



## БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

1. Сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг
2. Сургууль, ахуйг дэмжих хөтөлбөр

## III

## БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

## 1. Сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг

**Сургуульд ороход бэлдэх зардал (Хот, аймаг тус бүр ялгаатай байдаг)**

· Бага дунд ахлах сургуулийн 1 дүгээр ангид элсэж байгаа сурагчдад олгодог сургуульд орох бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэх зардал нь хот, аймгаас хамаараад ялгаатай байдаг

※ Сургуульд ороход бэлдэх зардалд үзүүлэх мөнгөн дүн нь тухайн орон нутгаас хамаараад ялгаатай байдаг тул оршин суугаа газрынхаа харъяа боловсролын газар, боловсролыг дэмжих газраас лавлана уу.

**Дүрэмт хувцсанд үзүүлэх дэмжлэг (Хот, аймгаас хамаараад ялгаатай)**

· <sup>1)</sup>Сургуулийн дүрэмт хувцас худалдан авах ажлыг сургуулиас нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа <sup>2)</sup>болон тэтгэмжийн мөнгийг мобайл поинтоор дамжуулан өгч, худалдаж авах барааны нэрийг заасан тохиолдол байдаг тул урьдчилан шалгасны дараа үйлчлүүлнэ үү.

**Доогуур орлоготой өрхийн бага дунд ахлах сургуулийн хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлэг, хичээлийн төлбөрийн тэтгэлэг**

· Доогуур орлоготой өрхийн хүүхдэд зориулсан 'боловсролын тэтгэмж', гадаадад амьдарч байгаад ирсэн доогуур орлоготой өрхийн хүүхдэд зориулсан 'сургалт, хөтөлбөрийн зардал' зэрэг дэмжлэг үзүүлэх бодлого хөтөлбөр хэрэгждэг тул захиргааны халамжийн төвд хандаж хамрагдах боломжтой эсэхийг шалгаад өргөдөл гаргах боломжтой.

※ Боловсролын тэтгэмж, сургалт хөтөлбөрийн зардлыг давхар олгодоггүй тул тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасны дараа өргөдөл гаргана.

**Лавлах**

- Эрүүл мэнд, халамжийн зөвлөгөө өгөх төв: ☎ 129
- Сургалтын төлбөрийн зөвлөгөө өгөх төв: ☎ 1544-9654
- Бүх орон нутгийн гэр бүлийн төв: ☎ 1577-9337
- Оршин суугаа газрын харъяа өб-мөнх-хорооны халамжийн төв, сургууль, харъяа боловсролын газар(боловсролыг дэмжих газар)

※ [Хавсралт 4] Сургуульд орох, сургалтын хөтөлбөрийн зөвлөгөө өгөх төв

## 2. Сургууль, ахуйг дэмжих хөтөлбөр



**Орон нутгийн хос соёлын боловсролыг дэмжих төв (Хавсралтыг үзнэ үү)**

· Хот, аймагт нийт 17 боловсролын төв үйл ажиллагаа явуулж байна. Энд цагаачилж ирсэн сурагч, эцэг эхийн албан боловсрол, дасан зохицоход үзүүлэх дэмжлэг, хос соёлын боловсролын туршлага судлах хөтөлбөр, цагаачилж ирсэн хүүхдэд зориулсан солонгос хэлний сургалт, ирээдүйд эзэмших мэргэжил судлах хөтөлбөр зохион байгуулдаг.



**Солонгосын эрүүл гэр бүлийг дэмжих төв Гэр бүлийн төв Танүри 1577-1366**

· Хос соёлт гэр бүлийг солонгос нийгэмд дасгах зорилгын хүрээнд гэр бүлийн гишүүдийн харилцааг сайжруулах сургалт(гэр бүл, хүйсийн тэгш эрх, хүний эрхийн сургалт), солонгос хэл, явуулын сургалт, зөвлөгөө, мэдээллээр хангах, солонгос иргэнтэй гэрлэсэн гадаад эмэгтэйчүүдэд зориулсан бичиг-ярианы орчуулгын үйлчилгээ, хүүхдийн ярианы хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлнэ. Нийт орон нутгийн хэмжээнд 244 төв үйл ажиллагаа явуулж байна.

· **Танүри дуудлагын төв (☎ 1577-1366)**

- Солонгост амьдарч байгаа хос соёлт гэр бүл-цагаач эмэгтэйчүүдийг солонгос ахуйн мэдээллээр хангах, асуудал тулгарсан үед зөвлөгөө өгөх, яаралтай тусламж үзүүлэх, ахуйн ярианы орчуулгын гурвалсан холбоонд суурилсан орчуулгын үйлчилгээ үзүүлнэ.
- 13 орны хэл дээр унаган хэлтэй цагаач эмэгтэйчүүд мэргэжлийн зөвлөгөө өгдөг тул эх хэлээрээ утсаар зөвлөгөө авах боломжтой.
  - ※ Зөвлөгөө авсан хүний хувийн мэдээлэл, үйлчилгээний нууцыг хадгална.
- **Үзүүлэх үйлчилгээ**
  - Дайжих төв үйл ажиллагаа явуулж байна. Энд яаралтай зөвлөгөө, хүчирхийлэлд өртөгсдөд зориулсан зөвлөгөө, яаралтай тусламж үзүүлэх байгууллагад холбох үйлчилгээ үзүүлдэг.
  - Гурвалсан харилцаа холбооны үйлчилгээгээр дамжуулан ахуйн мэдээллээр хангах, ахуйн хэрэглээний ярианы орчуулгын үйлчилгээ(Солонгосын өмгөөлөгчдийн холбоонд холбон өгч хуулийн зөвлөгөө өгнө) үзүүлдэг.



**WEE CLASS хөтөлбөр (Сургууль)**

· Сургуульдаа дасаагүй, хүнд асуудалтай тулгарсан хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлон-зөвлөгөө өгч-сэтгэл зүйг засдаг One-Stop үйлчилгээгээр дамжуулан гэр, сургууль, нийгэмд дасахад нь дэмжлэг үзүүлэх зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийн ухамсар, сэтгэл зүй, үйл хөдөлгөөнд илэрч байгаа асуудлыг зөвөөр ойлгуулж, шийдэхэд нь тусална(Мэргэжлийн зөвлөгч байнга байдаг тул асуудал тулгарсан үед хүссэн цагтаа WEE CLASS дээр ирж зөвлөгөө авах боломжтой)



**Цагаачилж ирсэн өсвөр насны хүүхдийг дэмжих сан Солонго өсвөр насны хүүхдийн төв 02-733-7587**

· Цагаачилж ирсэн өсвөр насны хүүхэд(Хойд солонгосоос дүрвэж ирсэн-гадаад улсад амьдарч байгаад ирсэн-хос соёлт гэр бүлийн өсвөр насны хүүхэд)-д зөвлөгөө өгөх мэргэжлийн байгууллага. Цагаачилж ирсэн өсвөр насны хүүхдийг солонгос нийгэмд дасгах, сурч, бие даах чадварыг нь хөгжүүлэх зорилгоор солонгос нийгмийн тухай ерөнхий мэдээлэл өгч, солонгос хэл, нийгмийн харилцаанд оролцох чадварыг нь дээшлүүлэх хөтөлбөр зохион байгуулдаг.

## PART IV



# ХАВСРАЛТ

[Хавсралт 1] Албан сургалтанд хамрагдах(сургуульд орох)-д хэрэглэгдэх нэр томъёо

[Хавсралт 2] Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эцэг, эхчүүдэд зориулсан бичлэг

[Хавсралт 3] Солонгос хэлний төлбөргүй сургалт явуулдаг вэб сайт

[Хавсралт 4] Сургуулийн элсэлтийн журам, сургуулийн үйл ажиллагааны тухай зөвлөгөө өгөх төв

## VI

## ХАВСРАЛТ



### <Хавсралт 1> Албан сургалтанд хамрагдах(сургуульд орох)-д хэрэглэгдэх нэр томъёо

Нэр томъёо	Үндсэн агуулга
Чиглүүлэх сургалт явадах өдөр	Хүүхдийнхээ элсэж орох сургууль дээр очиж, нэгдүгээр ангид орох насанд хүрсэн мэдэгдлийн хуудсыг бөглөж, заавар авна.
Сургуульд элсэх	Бага дунд ахлах сургуулийн 1-р ангид орох
Сургуульд орох	Заавал хамрагдах боловсролын байгууллагад хамрагдах сургуулийн зохих ангид орох
Сургуульд сурах	Тухайн хичээлийн жилд сурч байгаа(сурагчийн бүртгэлтэй) сурагч
Хичээлийн улирал	Сургалтын хөтөлбөрийг харгалзан нэг хичээлийн жилийг хуваасан хугацаа. Нэг хичээлийн жилийг ихэвчлэн 3-8 сар, 9-2 сарын хооронд хоёр улиралд хуваадаг.
Хичээлийн амралт	Улирлын эцэс, хичээлийн жилийн эцэст сургууль(цэцэрлэг)-ийн хичээлийг тодорхой хугацаагаар зогсоож амраахыг хэлнэ (*Зуны амралт, өвлийн амралт, хаврын амралт)
Хичээл эхлэх	Сургууль(цэцэрлэг)-ийн амралт дуусч үндсэн сургалт дахин эхлэх өдөр
Төгсөлт	Сурагчид(хүүхэд) сургуулийн дотоод журмын дагуу зохих сургалтын хөтөлбөрт хамрагдаж дуусахыг хэлнэ.
Улирах	Тухайн ангийн сургалтын хөтөлбөрийг дүүргэж чадаагүйн улмаас дээд ангид дэвшин суралцаж чадаагүй
Сургуулиас чөлөө авах	Өвчин зэрэг шалтгааны улмаас сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгээр тодорхой хугацаагаар сургалтын хөтөлбөрт хамрагдахыг зогсоосон
Сургуульд орох хугацааг хойшлуулах	Сургуульд орох ёстой хугацааг дараа жилийн хичээлийн жил хүртэл хойшлуулах
Өөр сургууль руу шилжих	Сурч байгаа сургуулиасаа гарч өөр сургууль руу шилжих



### <Хавсралт 2> Цагаач хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эцэг, эхчүүдэд зориулсан бичлэг



**Цагаачилж ирсэн хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-д зориулсан албан сургалтанд хамрагдах заавар бүхий видео бичлэг** нь солонгос хэл дээр байдаг бөгөөд 14 орны хэл(Англи, япоон, хятад, тагалог(филиппин), вьетнам, орос, франц, монгол, кхмер, тайланд, араб, мьянмар, узбекстан, индонез) дээр орчуулсан хадмалтай бичлэг нь YouTube дээр байдаг.



**Цагаачилж ирсэн хүүхэд(хос соёлт гэр бүлийн хүүхэд)-ийн эцэг эхчүүдэд зориулсан бага сургуулийн сургалтын үйл ажиллагаа болон сургуульд ороход бэлдэх гарын авлагад** солонгос улсын боловсролын тогтолцоо, бага сургуульд элсэж орох, төгсөх тухай бүхий л мэдээллийг солонгос хэл дээр бичсэн байдаг бөгөөд 7 орны хэл(англи, япон, хятад, орос, франц, вьетнам, филиппин) дээр орчуулсан хадмалтай бичлэг нь YouTube дээр байдаг.



Хос соёлын боловсролын цахим хуудас(edu4mc.or.kr)-ны архив болон Хос соёлын боловсролын төв центр(@edu4mc)-ийн YouTube сувгийг үзнэ үү.



### <Хавсралт 3> Солонгос хэлний төлбөргүй сургалт явуулдаг вэб сайт

<p>EBS Дуриань (ebs.co.kr/durian)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Солонгос хэл, соёл сурахад зориулсан солонгос хэлний сургалтын хөтөлбөр, цагаач гэр бүлд зориулсан EBS хос соёлын контент</li> <li>- 4 гадаад хэлний үйлчилгээ(солонгос, хятад, англи, вьетнам)</li> </ul>
<p>Өсвөр насны хүүхдийн улсын номын сан, олон үндэстний ардын үлгэр (nlcy.go.kr/NLCY/contents/C10503010000.do)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Солонгос ардын үлгэр, туулийг флаш анимэйшнээр танилцуулна</li> <li>- 9 орны хэл(солонгос, хятад, вьетнам, тайланд, монгол, англи, орос, камбож, тагалог) дээр орчуулсан олон үндэстний ардын үлгэр</li> </ul>
<p>Нүри-Сэжун академи (nuri.iksi.or.kr)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Солонгос хэл, соёлын төрөл бүрийн сурах бичиг, сургалтын материал</li> <li>- 16 гадаад хэлний үйлчилгээ(солонгос, англи, хятад, япон, вьетнам, монгол, тайланд, индонез, орос, испани, франц, португаль, малай, араб, узбек, хинди)</li> </ul>
<p>Дүрү номын дэлгүүр (두루책방.com)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үг холбож богино өгүүлбэр бүтээдэг номноос эхлээд 6 шатны унших дасгалтай материал</li> <li>- Гадаад хэл цэсээр дамжуулан 5 гадаад хэл дээр бэлтгэсэн сургалтын материал(солонгос, вьетнам, хятад, тайланд, англи)</li> </ul>
<p>Dubbing school TV (youtube – 더빙스쿨TV гэж хайна)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сайн уншиж чадахгүй 1-2-р ангийн хүүхдэд зориулсан 4 гадаад орны хэл дээр орчуулсан бичлэг(орос, вьетнам, хятад, монгол)</li> <li>- Уншиж чаддаг 3-6-р ангийн хүүхдэд зориулсан 6 гадаад хэл(орос, вьетнам, монгол, хятад, англи, япон)-ний хадмал орчуулгатай бичлэг</li> </ul>
<p>Хилийн чанадад амьдарч байгаа солонгосчуудын сан Стади кореан (study.korean.net)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад улсад амьдардаг солонгос иргэдэд зориулсан солонгос хэл сурах цахим хуудас бөгөөд гадаад улсад амьдардаг солонгос иргэн биш ч гэсэн солонгос хэл сурах боломжтой.</li> <li>- Солонгос соёлын материалыг сайтад нэвтрэхгүйгээр үзэх боломжтой.</li> <li>- Солонгос хэл сурахын тулд сайтад гишүүнээр элсэж нэвтэрсний дараа сургалтанд хамрагдах хүсэлт гаргана.</li> </ul>
<p>Олли Болли зурагтай үлгэрийн ном (ollybolly.org)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад орны үлгэрийн зурагт номын сайт(Солонгос, ливан, руанда, монгол, вьетнам, узбестан, иран, индонез, хятад, камбож, тайланд, төвд, палестин, филиппин)</li> <li>- Гадаад орны үлгэрийн номыг тухайн улсын хэлнээс гадна солонгос, англи хэл дээр орчуулсан</li> <li>- Зурагт үлгэрийн ном, улсын нэрээр хайлт хийх боломжтой</li> </ul>
<p>Бүх насны хүнд зориулсан солонгос хэлний сурах бичиг (korean.edunet.net)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Анхан, дунд шатны солонгос хэлний хичээл үзэж, даалгавар хийх боломжтой</li> </ul>



**<Хавсралт 4> Сургуулийн элсэлтийн журам, сургуулийн үйл ажиллагааны тухай зөвлөгөө өгөх төв**

Байгууллагын нэр	Утас
СӨҮЛ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	070-4832-8327-8
БУСАН ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	051-819-7062
ТЭГҮ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	053-231-2925
ИНЧОНЬ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	032-420-8269
ГУАНЖУ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	062-940-8955
ТЭЖОН ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	042-616-8856
ҮЛСАН ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	052-255-8180
СЭЖУН ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	044-320-2141
КЁНГИ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	031-820-0696-8

Байгууллагын нэр	Утас
КВАН ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	033-258-5448
ЧҮНБУГ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	043-210-2831
ЧҮННАМ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	041-640-7232,7234
ЧОНБУГ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	063-239-3482
ЧОННАМ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	061-640-3330
КЁНБУГ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	054-805-3264
КЁННАМ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	055-210-5162
ЧЭЖҮ ХОС СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨВ	064-784-9041



[PM2025-1]

ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД) АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ,  
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

## ХҮҮХЭД СУРГУУЛЬД ОРУУЛАХ

Хэвлэсэн огноо:	2025 оны 6 сар
Гаргасан:	НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ТӨВ
Хэвлүүлсэн:	Шим Хань Шиг, захирлын орлон гүйцэтгэгч
Зохиогч :	Ли Жинь Хи(Сөүл хотын боловсролын төв), Ли Хе Рим(Чонбүг Чолла Намду мужийн боловсролын газар), Гү Минь Жон(Кёнсан-намду боловсролын төв)
Хянасан:	Ким Жон Ми-Пак Эсто(Сөүл хотын Боловсролын газар), Ким Минь Жү(Инчонь хотын Боловсролын газар), Жу Юүнь Жээ(Гуанжү хотын Боловсролын газар), Пак Ми Уг(Үлсань хотын Боловсролын газар), И Жээ Гён(Чүнчон-Бүгду аймгийн Боловсролын газар), Ким Хань Бид(Чолла-Намду аймгийн Боловсролын газар)
Судалгааны хамтын ажиллагааны хэлтэс:	Пак Жи Ээ-Ян Га Юүнь(Боловсролын яам), Ли Хёнъ Ү- Ли Су Хёнъ(Хос соёлын боловсролын төв центр)
Хаяг:	БНСУ, Сөүл хот, Кансо-гү, Магүгжүнан-ру 105-7, Насан туршийн боловсролыг дэмжих төв, 4 давхар (ШХД)07800
Утас	02-3780-9943
Факс	02-3780-9959
Цахим хуудас:	Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний төв( <a href="#">www.nile.or.kr</a> ) Хос соёлын боловсролын төв центр( <a href="#">www.edu4mc.or.kr</a> )
Дизайн-орчуулга	DoubleKnew Company

※ Энэхүү гарын авлагын зохиогчийн эрхийг Боловсролын яам, Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний төв, 17 хот-аймгийн болосролын төв эзэмшинэ.

※ Энэхүү гарын авлагыг зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүхэлд нь ашиглах, ишлэх, хуулбарлахыг хориглоно.



2025  
ХҮҮХЭД  
СУРГУУЛЬД ОРУУЛАХ



ЦАГААЧИЛЖ ИРСЭН ХҮҮХЭД(ХОС СОЁЛТ ГЭР БУЛИЙН ХҮҮХЭД)  
АЛБАН СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ ЭЦЭГ,  
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА